



**НИЙСЛЭЛИЙН
ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ**

Чин Ван Г. Чагдаржавын гудамж, 1 дүгээр хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14210
Утас/Факс: (976-11) 32-18-11
И-мэйл: nttt@103.ub.gov.mn
Вэбсайт: www.103.ub.gov.mn

2020. 05. 25 № 02/195

танай _____-ны № _____-т


Г НИЙСЛЭЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАРТ Г

Тус төвийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн аудитын хяналт, шалгалтаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын дагуу хэрэгжүүлсэн ажлын тайланг хүргүүлж байна.

Хавсралт 3. хуудастай.

Хувийг Нийслэл дэх Төрийн аудитын газарт

ЗАХИРАЛ



Ц.ПҮРЭВДАШ

314070330

НИЙСЛЭЛИЙН ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ТӨВ

2019 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТААР ӨГСӨН ЗӨВЛӨМЖ,
АЛБАН ШААРДЛАГЫН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

2020 оны 05 сарын 21

Д/д	Аудитын зорилго, чиглэл	Зөвлөмж, албан шаардлага	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
ЗӨВЛӨМЖ						
1.	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй	-	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" заалтыг хэрэгжүүлэх зөвлөмж өгөх	НБББББ-ийг "Нью Эстимэйтор Аудит" ХХК-тай зөвлөхийн үйлчилгээний гэрээгээр 2020.01.02-2020.04.13 ны хооронд хийж гүйцэтгүүлэн тус төвийн захирлын 2020.0.15-ны өдрийн А/21 дугаар тушаалаар 2020 оны тайлант хугацааны эхнээс мөрдөж ажиллахаар баталгаажуулав.	100 хувь
2	Үндсэн хөрөнгийн талаар	Элэгдлээрээ анхны нөхсөн боловч ашиглагдаж байгаа 284 нэр төрлийн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.	-	УСНББОУС-17-ийн 55-д "...хөрөнгийн үнэ цэнэ нь түүний дансны үнээс илүү байх тохиолдолд ч элэгдлийн шимтгэлийг байгуулна" гэсэн заалтыг хэрэгжүүлж Үлдэх өртөггүй ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлгээ хийлгэх эсэхийг шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> - 2020 онд 37 нэр төрлийн 150,166.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг цаашид ашиглахгүй гэж үзэн НӨАУГ-ын 2020.04.02 А/136, 2020.03.30 4/603, 2020.05.14 А/665 дугаар шийдвэрээр данс бүртгэлээс хассан. - 70 нэр төрлийн 94,762.5 мянган төгрөгийн хөрөнгөнд ойрын 2-оос дээш ашиглана гэж үзэн үнэлүүлэхээр НӨАУГ-тай зөвлөлдөн хэрхэн үнэлэх асуудлыг цаашид шийдвэрлүүлнэ. - Ашиглалтын хугацаа дууссан 39 ширхэг 1,983,271.9 мянган төгрөгийн автомашиныг парк шинэчлэлт хийгдэх хүртэлх хугацаанд засвар, үйлчилгээний хүчээр ажиллуулж байгаа тул үнэлэх боломжгүй. 	58.9 хувь

					<p>Ойрын хугацаанд /1-2 жил/ ашиглан данс бүртгэлээс хасах болон эвдрэх эрсдэлтэй 102 нэр төрлийн 1396,246.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэлэхгүйгээр ашиглаж уг хугацаанд шийдвэрлэнэ.</p> <p>Уг шийдвэрээр нийт 6425542 төгрөг олгохоос 2019 ондоо 4191833 төгрөгийг олгож 459221 төгрөгийн татварыг хасаж үлдэгдэл төлбөрийг 2020.01.16 ны өдөр НШШГГ-т шилжүүлэн тооцоог бүрэн барагдуулсан.</p>	100 хувь
3	Өр, авлагын талаар	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт 2019 оны 2/21601 тоотын дагуу төлөөгүй үлдэгдэл өглөг үүсгээгүй	2,431.5	Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2019 оны 2/21601 тоот албан бичигт тусгагдсан төлбөр хэрэгжих шатандаа байгаа учир цаашид хэрэгжилтийг бүрэн хангах		
4	Анхан шатны маягт	Нормчлоогүй ажлын өдөртэй захиргааны ажилтанд илүү цагийн хөлсийг тушаал шийдвэргүй олгосон. ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, дугаар хавсралт, "нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас" хөтлөөгүй байна.		ЗГ-ын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын "нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй байна.	<p>Тус төв нь тасралтгүй 24 цагийн үйл ажиллагаатай учраас 420 орон тооноос дундаж 366 нь ээлжийн ажилчид буюу дийлэнх нь болно.</p> <p>Үлдсэн 54 орон тоо нь оффисын нормчлогдоогүй бөгөөд дээрх ээлжийн дуудлагад ажиллахаас бусад ээлжийн амралттай, бэлэн байдлын үеийн жижүүр, хяналтаар ажилласан, автомашины засварыг ажлын бус өдрүүдэд засварласан, автомашиныг шалгаж ажилд гаргасан инженер техникийн ажилчид зэрэг нэмэлт ажлуудад нөхөн ажилласан 1-5 сарын байдлаар нийт 47 ажилтанд "нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас" хөтөлсөн.</p>	100 хувь

2. АЛБАН ШААРДЛАГА

5	Цалин хөлсний талаар	Өөрийн хүсэлтээр тэтгэврээ тогтоолгосон ахмад настан 14 хүнд өмнө авч байсан цалин болон нэмэгдэл хөлсийг	11,898.9	Төрийн албаны тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2.2-т зааснаар төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагч өндөр насны тэтгэврээр тогтоолгохоор өөрийн хүсэлтээр төрийн албанаас чөлөөлөгдсөний дараа төрийн алба	<p>2020.01.01-ээс эхлэн 14 ахмад, настанд өмнө нь авч байсан цалинг бууруулан зэрэглэл тус бүрийн хамгийн бага цалингийн 1-р сүлжээний шатлалаар тогтоосон.</p> <p>Захирлын Б/70 тушаалаар 2020.01.21-ээс эхлэн тус ажилтнуудын</p>	91.6 хувь
---	----------------------	---	----------	---	---	-----------

			<p>хаах насны дээд хязгаар хүртэл төрийн албанд хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж болох бөгөөд цалин хөлс нь зөвхөн хөдөлмөрийн гэрээнд зааснаар тодорхойлогдоно. Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.2, 57.2.4 дэх хэсэгт зааснаар тэтгэвэрт гарахынхаа өмнө авч байсан цалин хөлсийг сэргээж олгох эрх зүйн үндэсгүй</p>	<p>зэргийн, ур чадварын, нууцын, бохирын нэмэгдлүүдийг хассан. Иймд өмнө авч байсан цалин хөлсийг сэргээж олгосон зөрчлийг арилгасан болно.</p>	
	ДҮН	14,330.4			Дундаж 90.1 хувь



ЗАХИРАЛ *Ц.Пүрэвдаш*
 АХЛАХ НЯГТЛАН БОДОГЧ *Б.Отгонтэнгэр*
 Ц.ПҮРЭВДАШ
 Б.ОТГОНТЭНГЭР